



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5- 12
<hr/>	
Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа	5-8
1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх	9-10
2. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	11
3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл сонсох	хаалттай

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
08 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганмаа;

Чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Д.Бум-Очир, Б.Мөнхсоёл;

Тасалсан: М.Бадамсүрэн, Д.Батлут, Ж.Ганбаатар, Д.Ганбат, С.Лүндэг, П.Мөнхтулга, Н.Наранбаатар;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан- 18 минут, О.Алтангэрэл- 01 минут, С.Амарсайхан- 06 минут, Ц.Баатархүү- 15 минут, Э.Бат-Амгалан- 02 минут, Д.Батбаяр- 04 минут, Р.Батболд- 01 минут, Х.Баттулга- 34 минут, Б.Батцэцэг- 09 минут, П.Батчимэг- 12 минут, Ж.Баярмаа- 09 минут, Б.Бейсен- 01 минут, Х.Болормаа- 11 минут, Ш.Бямбасүрэн- 51 минут, А.Ганбаатар- 03 минут, Г.Ганбаатар- 04 минут, Л.Гантөмөр- 02 минут, Х.Ганхуяг- 04 минут, Ц.Даваасүрэн- 04 минут, Б.Жавхлан- 07 минут, Б.Жаргалан- 35 минут, Д.Жаргалсайхан- 20 минут, С.Замира- 09 минут, Ж.Золжаргал- 04 минут, Г.Лувсанжамц- 01 минут, Ц.Мөнхбат- 14 минут, Ц.Мөнхтуяа- 10 минут, Б.Найдалаа- 02 минут, П.Наранбаяр- 01 минут, М.Нарантуяа-Нара- 02 минут, С.Одонтуяа- 01 минут, Л.Оюун-Эрдэнэ- 12 минут, Б.Пунсалмаа- 29 минут, Д.Пүрэвдаваа- 05 минут, П.Сайнзориг- 1 цаг 21 минут, Ц.Туваан- 09 минут, Б.Тулга- 04 минут, А.Ундраа- 04 минут, Дам.Цогтбаатар- 42 минут, О.Цогтгэрэл- 31 минут, Ж.Чинбүрэн- 01 минут, Б.Чойжилсүрэн- 01 минут, Ж.Энхбаяр- 01 минут, Д.Энхтуяа- 05 минут, С.Эрдэнэбат- 1 цаг 05 минут, С.Эрдэнэболд- 01 минут.

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа**

Танхимд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар суудлаа эзэлсэн байв.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв./10:15/

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэх**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88  
Татгалзсан: 19  
Бүгд: 107  
82.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Дамдинням, Х.Баасанжаргал, Б.Батцэцэг, С.Зулпхар, Р.Сэддорж, М.Нарантуяа-Нара, С.Замира, М.Энхцэцэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр тооцов.

Монгол Улсын Их Хурлын чуулганаар тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 93  
Татгалзсан: 14  
Бүгд: 107  
86.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 89  
Татгалзсан: 18  
Бүгд: 107  
83.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Мандхай, Т.Мөнхсайхан, Ж.Энхбаяр, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр тооцов.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга тогтоолын төслийн талаар танилцуулав.

**Д.Амарбаясгалан:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 93  
Татгалзсан: 16  
Бүгд: 109  
85.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:31/

*Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл сонсох /хаалттай/***

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 32 минутаас хаалттай горимоор дээрх мэдээллийг сонсов.*

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 12 цаг 07 минутад нээлттэй горимд шилжин хуралдаан үргэлжлэв.*

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын студи, МҮОНРТ-ийн Монголын мэдээ суваг, Монгол кино нэгтгэл, Ийгл телевиз, Парламент телевиз, Live TV, ТМ телевиз, Юнивишн, Скаймедиа кабелийн суваг, “МОНЦАМЭ” агентлаг, news.mn, gogo.mn, eguug.mn, itoim.mn, mpa.mn сайт, “Зууны мэдээ” сонин зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагын болон Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн, мөн Ерөнхий сайдын ажлын албаны зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Нээлттэй хуралдаан 31 минут үргэлжилж, 126 гишүүнээс 115 гишүүн хүрэлцэн ирж, 91.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 09 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 03 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы ирц 54,8 хувьтай бүрдсэн байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы ээлжит бус хуралдааныг эхлүүлэе.

Монгол Улсын Ерөнхий сайд,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд,  
нийт ард иргэддээ хандаж үг хэлье.

2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан 126 гишүүнтэй манай парламентын өмнө хууль, эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх өндөр хариуцлагатай, өргөн цар хүрээтэй үйл хэрэг хүлээгдэж байна.

Өнөөгийн Монгол Улсын нийгмийн харилцааг 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан зарчим, үзэл санаа, түүнд нийцүүлэн боловсруулсан хууль тогтоомжоор зохицуулж байгаа.

Одоогийн байдлаар Улсын Их Хурлаас баталсан 880 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Эдгээр хуулийн 437 нь нийгмийн өдөр тутмын харилцааг тогтмол зохицуулж, даган мөрдөгддөг хуулиуд юм. Харин үлдсэн 443 хууль нь нэг удаагийн шинэжтэй үйлчилдэг хуулиуд байна.

Үүний зэрэгцээ, 1992 оны шинэ Үндсэн хуулиас өмнө батлагдсан 8 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Тухайлбал,

1957 онд батлагдсан “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай”;

1991 онд батлагдсан “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль” зэргийг дурдаж болно.

Мөн нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын бүртгэлтэй 2768 журмаар нийгмийн харилцааг зохицуулж байна.

Дээрхээс харвал, хууль тогтоомжийн 32 хувь нь хууль, 68 хувь нь захиргааны хэм хэмжээний акт болсон байна.

Энэ нь хуулиар зохицуулбал зохих харилцааг журмаар зохицуулахад хүрч, хуулиар албан тушаалтан, төрийн байгууллагад нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрхийг олгож ирснийг илэрхийлж байна.

Тодруулбал, хуулиар зохицуулбал зохих харилцааг журмаар зохицуулснаар хүний эрхэд халдах ноцтой үр дагаварт хүрсэн гэж болохоор байна.

Улмаар хууль, эрх зүйн орчны дээрх доголдол нь хуулийг үзэмжээр биелүүлэх, хүний эрхийг хязгаарлах үндэс болж, хууль дээдлэх зарчмыг алдагдуулж байна.

Иймээс энэ удаагийн 126 гишүүнтэй шинэ парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа дараах үндсэн чиглэлийг баримтлан ажиллана. Үүнд:

1. Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.



2.Хууль тогтоомжийг тодорхой ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгоно.

3.Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргадаг болно.

**Нэгдүгээрт, Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлж ажиллах чиглэл гэдэг нь:**

“Хүн төвтэй эрх зүйн тогтолцоо” үзэл баримтлалд тулгуурлан шинэчлэлийг хийхдээ хууль, тогтоомж нь иргэн хүний эрх ашиг, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байх” зарчмыг эн тэргүүнд тавина.

Энэ нь өнөөгийн төр, эсвэл байгууллага төвтэй үзэл баримтлал, хуулийн бичилт, арга техникээс хүн төвтэй үзэл баримтлал руу шилжих тухай бөгөөд мөрдөгдөж байгаа болон цаашид шинээр гарах хууль нэгэн адил хамаарна.

Хүний эрхийн олон улсын Гэрээ, конвенц болон манай холбогдох хууль тогтоомжид нэг талаас зорилтот бүлгийн асуудал, тухайлбал хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх гэх мэт.

Нөгөө талаас хүний эрхийн тодорхой асуудлууд. Тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, өмчлөх, хөдөлмөрлөх эрх зэрэг хоёр хүрээнд эрх зүйн орчны шинэчлэлийн асуудал хөндөгдсөөр ирсэн байдаг.

Нэг жишээ татахад, одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 318 хуульд шинжилгээ хийж үзэхэд хүний эрхийг зөрчсөн 800 гаруй зүйл, заалт байгаа нь тогтоогдсон байна.

Эрх зүйн энэ мэт зөрчлийг засаж залруулахад манай парламент хүч анхаарал тавьж ажиллана.

Манай парламент хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулахын тулд дараах асуудлуудыг судалж, шинээр хууль гаргах юм уу, одоогоор хэрэгжиж байгаа нэр бүхий хуульд өөрчлөлт оруулж, шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна.

Эрх зүйн хүрээний шинэтгэл хийхдээ бид Үндсэн хуулийнхаа суурь үзэл баримтлал болох хууль дээдлэх ёсыг тууштай сахин мөрдөх замаар Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэх, ялгаварлан гадуурхалтын эсрэг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,

Хууль тогтоомжийг боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах,

Гэрч, хохирогч, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах,

Хүнс, эмийн аюулгүй байдлыг хангахуйц зөв, үр нөлөө бүхий эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

Үүний зэрэгцээ зөвшилцлийн улс төрийн соёл, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд одоогийн улс төрийн болон эрх зүйн тогтолцоо хангалттай суурь болж чадаж байгаа эсэхийг нягталж үзэх ёстой.

Манай парламентын шинээр баталж гаргах хууль тогтоомж нь нийтийн эрх ашигт нийцсэн, хэрэгжүүлэх арга механизмыг нь боловсруулсан, нийгмийн харилцааг үр дүнтэй зохицуулж чаддаг, өндөр дээд ёс суртахууныг баримжаалсан байх болно гэдгийг баттай илэрхийлье.

**Хоёрдугаарт, Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэл гэдэг нь:**

Өмнө дурдсанаар, дийлэнх хуулиар зохицуулбал зохих харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж буй хууль дээдлэх ёсны энэхүү гажуудлыг засаж залруулахад манай парламент онцгой анхаарч ажиллана.



Учир нь, албан тушаалтан, төрийн байгууллагаас баталж буй эдгээр журмаар хуулиас давсан хэм хэмжээ тогтоож байгаа нь хүний эрхийг зөрчөөд зогсохгүй хүнд суртал, авлига, тодорхойгүй байдлыг бий болгож байна.

Иймээс, нийгмийн харилцааг аль болох журмаар бус хуулиар зохицуулахад чиглэн, хуулийн төслийг өргөн барихдаа журмын төслийн хамтаар өргөн мэдүүлдэг байх шаардлагыг тавьж, эрх зүйн орчныг илүү тодорхой болгохыг зорьж байна. Жишээлбэл, Европын холбооны улс орнуудад нийгмийн харилцааны 95 хувь нь хуулиар, 5 хувь нь захиргааны хэм хэмжээний акт буюу журмаар зохицуулагдаж байна. Энэ байдал нь хууль дээдлэх зарчим, орчин цагт улс орнуудын засаглалын шалгарсан арга болохыг илтгэж байгаа юм.

**Гуравдугаарт, Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргаж ажилладаг болох чиглэл гэдэг нь:**

Хуулиа дээдэлсэн өрсөлдөөний шударга нөхцөл, ил тод байдлыг хангасан эрх зүйн орчин нь хөгжил дэвшилд хүрэх үндсэн арга зам гэдгийг дэлхий нийтийн туршлага нотолж байна. Үүний тулд мөрдөж байгаа болон шинээр батлан гаргах хууль тогтоомж нь цаг үеийн болон нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн байх учиртай.

Энэ өнцгөөс нь авч үзвэл, манайд нийгмийн зарим харилцааг хангалттай түвшинд зохицуулж чадахгүй байгаа хуулиуд цөөнгүй байна. Ингэснээр зохицуулалтгүй асуудал ихээр хуримтлагдаж, салбар хоорондын харилцаанд тодорхойгүй байдал үүсэж, шинжлэх ухаан, технологийн ололт, инновацыг нэвтрүүлэх замд томоохон саад учруулж байна.

Үүнтэй холбоотойгоор одоо хэрэгжиж байгаа дараах хуулиудыг эргэж харах, мөн хэд хэдэн асуудлаар

шинээр хууль боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

#### **Дурдвал:**

- Бизнесийн орчныг сайжруулах, шударга өрсөлдөөнийг дэмжих, монополийг хязгаарлах эрх зүйн орчин хангалтгүй байна;

- Койн, Криптовалютын талаар хуулийн зохицуулалтгүй, түр журмаар зохицуулсантай холбоотой албан бус хохирлын хэмжээ хэдэн арван тэрбумаар яригдах хэмжээнд хүрсэн байна;

- мөн электрон тамхи;

- Аж ахуйн нэгж хоорондын худалдааны харилцааг зохицуулж байгаа 2002 оны Иргэний хуулийн заалтууд өнөөгийн шаардлага хангахгүй болсон;

- Хэрэглэгчийн эрхийн асуудлыг зохицуулж байгаа хууль шаардлага хангахгүй байна;

- Шүүн таслах үйл ажиллагааг цахимжуулах асуудал;

- Төрийн өмчийн ашиглалт, хяналтын харилцааг зохицуулах шинэ эрх зүй орчин мөн шаардагдаж байна.

Улс орныхоо хууль, эрх зүйн орчныг илүү сайжруулах хүрээнд манай парламентын өмнө тулгамдаж байгаа зөвхөн зарим асуудал гэвэл ийм байна.

Та бидний өмнө үүнээс ч олон асуудлыг шийдвэрлэх эрэлт хүлээлт байна.

Иймд, шинэ парламентын гишүүн та бид, эрх мэдэл гэхээс илүүтэйгээр иргэдийнхээ жинхэнэ төлөөлөл байж, улс орныхоо хөгжлийг хурдасгах үндсэн зорилгынхоо төлөө өндөр ёс зүйтэй, илүү бүтээлч, ил тод, хурдтай ажиллах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүнийхээ нэр төрийг өндөрт өргөж, “Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй үзэл

баримтлал бүхий”, “Хууль тодорхой, ойлгомжтой, ижил тэгш үйлчилдэг”, “Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцэхүйц” Монгол Улсынхаа хууль эрх зүйн орчны Гурван төгөлдөржилтийг бодит болгох ариун үйлсдээ хувь нэмрээ оруулж, үлгэр дуурайлал үзүүлж ажиллана гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Та бүхэндээ ажлын амжилт хүсье.

Ингээд Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагаа нээгдсэнийг мэдэгдье.

Төрийн дуулал эгшиглэв./10:15/

Ингээд ээлжит бус чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

10.15 цаг

Өнөөдрийн чуулганаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудлын тоо 3.

1 дүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

2. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг сонсоно.

Ингээд энэ Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх асуудал нь шинэ хурлын дэгээр чуулганы хуралдааны эхэнд санал хурааж яаралтай хэлэлцэх эсэх асуудал шийдвэрлэгддэг болсон байгаа.

Тэгээд үүнтэй холбоотой санал хураалт явагдана.

Мөн өмнөх анхдугаар чуулган дээр бас энэ санал хураалтын системтэй холбоотой бас доголдол үүсэж байсан. Тэгээд сая завсарлагааны хугацаанд энэ систем суурилуулсан аж ахуйн нэгж, Тамгын газар бас хамтарч ажиллаж, доголдлыг арилгах үйл ажиллагааг зохион байгуулсан байгаа.

Тэгэхээр өнөөдрийн энэ санал хураалтын ажиллагаа эхлэхээс өмнө, асуудлаа хэлэлцэж эхлэхээс өмнө нэг 3 удаагийн туршилтын санал хураалтыг явуулж өгөөч гэж Тамгын газрын зүгээс хүсэлт тавьсан.

Тэгэхээр Тамгын газрын дарга удирдаад 3 удаа туршилтын санал хураалтыг зохион байгуулж туршиж үзье, эхлээд.

Тамгын газрын даргад микрофон өгье.

**Б.Баасандорж:** Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Та бүхэнд хуралдааны системтэй холбоотой товч бас заавар, зөвлөмжийг та бүхэнд тараасан байгаа. Тэгээд яг заавар зөвлөмжийн дагуу одоо яг албан ёсны санал хураалт явахаас өмнө та бүхэн 3 удаа санал хураалтын туршилтын санал хураалт явуулж өгнө үү хэмээн хүсье.

**Д.Амарбаясгалан:** Туршилтын санал хураалт 1. Алх тогишиж явах юм байна. Эхний санал хураалт явуулъя.

Өөрсдийнхөө нэрээр санал өгсөн байдлаа хянаад явчихъя. Энэ урьд нь санал хураалт ер нь 10 секундэд зохион байгуулагддаг байсан. Тэгээд гишүүд шинэ байна, төхөөрөмж шинэ байгаа учраас секундийг жоохон нэмсэн байгаа. Тэгээд гишүүдийн нөгөө төхөөрөмжтэйгөө харьцах нөхцөл нь сайжраад ирэхээр санал хураалтын секундийг багасгаад явахаар зохицуулалтыг бас хийсэн байгаа гэдгийг хэлье.

2 дахь санал хураалтыг эхлүүлье. Гишүүд өөрийнхөө өгсөн саналыг дараа нь нэрээ хараад хянаад байгаарай.

Гишүүд маань нэрээ хараад хянаж байгаа байх, тийм ээ.

3 дахь санал хураалтыг явуулъя. 3 дахь санал хураалт дээр бүгд “зөвшөөрсөн”-өөр саналаа өгч үзье. Санал хураалт эхлүүлье.

Энэ 8 гишүүн байхгүй байна. Бат-Амгалан байхгүй, Батжаргал гишүүнийх уншаагүй юу. Хурууны хээ танихгүй байна уу. Пүрэвдорж гишүүн татгалзсан юм уу.

Тэгэхээр яах вэ, ахиж санал хураалт хурааж туршиж үзэх үү. Ахиад нэг 2 удаа санал хураалт хураая.

Бүгдээрээ “зөвшөөрсөн” дээр 1 удаа санал хураалт хураагаад, ахиад “татгалзсан” дээр нэг санал хураачихъя.

Эхнийх “зөвшөөрсөн”-өөр санал хураалт явуулъя.

Аубакир гишүүнийх яасан, болохгүй байна уу?

Манай Эрдэнэболд гишүүний төхөөрөмж гацаж байна уу? Саатал өмнөх шиг, засагдсан байгаа биз. Өмнө нь бас энэ шугам дээр бас алдаа гараад дандаа хоцрогдолтой яваад байсан юм байна лээ. Яг тэр сүүлийн эгнээнд сууж байгаа хүмүүсийн төхөөрөмжийн үйл ажиллагаа нь.

Тэгвэл одоо ганц нэг хурууны хээ танихгүй байгаа нөхцөлөөс бусад нь болж байна гэж үзэж болохоор байна, тийм ээ.

Одоо тэгвэл бүгдээрээ “татгалзсан”-аар сүүлийн санал хураалтыг явуулж үзье.

Манай Жавхлан гишүүн чинь ер нь дандаа зөвшөөрдөг л хүн байна даа. Сангийн сайд ганцаараа имидж гаргаж байна шүү дээ.

Баярлалаа. Ингээд микрофоноо нээгээд хурлынхаа үйл ажиллагаанд оръё.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх асуудлыг шийдвэрлэхээр орж байна.

**Улсын Их Хурлын чуулганаар хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр “Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Ингээд “Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

*Дэмжье гэсэн санал хураалт.*

Санал хураалтад 107 гишүүн орж, 88 гишүүн дэмжиж, 82,2 хувиар дэмжигдлээ.

Батжаргал гишүүн дэмжиж, санал өгсөн орсонгүй, протоколд гэж байна. Дамдинням гишүүн, Баасанжаргал гишүүн, Батцэцэг гишүүн, Зулхар гишүүн, Сэддорж гишүүн, Нарантуяа-Нара гишүүн, Замира гишүүн гээд гишүүд, тийм, Энхцэцэг хэлсэн.

Гишүүдийг дэмжиж санал өгснөөр протоколд тэмдэглэлээ.

Тэгээд бүгдээрээ богино хугацаанд энэ төхөөрөмжтэйгөө зөв харьцаж сурах хэрэгтэй байх. Тэгээд хурууны хээгээ уншуулахдаа тэр даралтынхаа чанга, сулыг бас их тааруулах учиртай юм шиг байна лээ.

Ингээд тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Одоо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

Санал хураалтад 107 гишүүн оролцож, 93 гишүүн дэмжсэнээр санал дэмжигдлээ.

Одоо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 107 гишүүн оролцсоноос 89 гишүүн дэмжиж, 83,2 хувиар дэмжигдлээ.

Дэмжиж өгсөн гишүүд протоколд тэмдэглүүлье. Тийм ээ.

Энхтүвшин, Мандхай,  
Мөнхсайхан, Энхбаяр.Ж, Цэнгүүн  
төхөөрөмж ажиллахгүй байна.

Тамгын газрын хүмүүс очоорой.

Эдгээр гишүүд протоколд тэгээд юугаа тэмдэглүүлчихье.

Олон санал хураалт явж байгаа учраас бас арай хялбаршуулах үүднээс. Хууль,

Одоо хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.



Хэлэлцэх асуудал 2-т оръё.

**“Зарим байнгын хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүрэлдэхүүнтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Батмөнхийн Батцэцэг, Ухнаагийн Отгонбаяр нарыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Сүрэнжавын Лүндэгийг Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны, Батжаргалын Заяабал, Болдын Уянга нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Болдын Жавхланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Сүрэнжавын Лүндэг, Болдын Уянга нарыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Болдын Жавхланг Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны, Бат-Өлзийн Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Батмөнхийн

Батцэцэг, Жамбалын Ганбаатар нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Батжаргалын Заяабал, Ухнаагийн Отгонбаяр нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Хассуурийн Ганхуягийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёолоор санал хураалтыг явуулна.

Санал хураалт.

Санал хураалтад 109 гишүүн оролцсоноос, 93 гишүүн дэмжсэнээр санал дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.31 цаг

**Ингээд хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг сонсохоор байгаа.**

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл хаалттай горимоор үргэлжлэн явагдана.

Бэлтгэл хангахад 5 минут зарцуулагдана.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг бас Их Хурлын чуулганы танхимд урьж байна.

**Хаалттай горимд шилжив.**  
/10:32/

**Нээлттэй горимд шилжив.**  
/12:07/

**Д.Амарбаясгалан:** Ингээд чуулганы нэгдсэн хуралдаан нээлттэй горимд шилжсэн байна./12:07/

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаанд зарлан мэдээлэх үүргийг хүлээдэг.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байдаг. Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг танилцуулъя.

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2. “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд,

5. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Баярбаатар нарын 6 гишүүн.

Ийм 5 асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэнэ гэдгийг бас та бүхэнд зарлан мэдээлж байна.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

Байнгын хороо намын бүлгүүд хуралдана.

Түүнээс өмнө даргын дэргэдэх зөвлөл товч хуралдаж, хуулийг хэлэлцэх журам батлахаар байгаа. Одоо манай өрөөнд хурал хуралдана.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**